ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

# ТӨГСӨЛТИЙН ТӨСӨЛТ /ДИПЛОМ/-ЫН АЖИЛ

## ХАБЭА-н урьдчилсан зааварчилгааны видео контент


**Удирдсан багш:** **Б. Мэндбаяр**

**Төсөлт ажлыг гүйцэтгэсэн:** **С. Маралмаа**

**Г. Энхжин**

**Б. Мөнгөнцэцэг**

**Ц. Мягмарцогт**

**О. Мөнхтулга**

**Л. Хүрэлчулуун**

**Д. Шинэбаяр**


**Чойр хот**

**2022 он**

УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

20[illegible]оны ..[illegible]сарын [illegible]өдөр

ДИПЛОМЫН АЖЛЫН ДААЛГАВАР

[illegible]

..........................................овогтой ..............................................нд

Дипломын сэдэв [illegible]

[illegible]

...................................................................................................................................

Судалгааны үндсэн хэсэг...................................................................................................

[illegible]

[illegible]

...................................................................................................................................

Судалгааны дүгнэлт, санал...............................................................................................

...................................................................................................................................

...................................................................................................................................

...................................................................................................................................

Удирдагч багшийн үнэлгээ [illegible]

Дипломын ажлыг эхэлсэн: 20.....оны.........сарын.........өдөр

Диплом ажлыг дууссан 20.....оны.........сарын.........өдөр

Удирдагч багш / /

Урьдчилсан хамгаалалтанд орох: 20.....оны.........сарын..........өдөр

Жинхэнэ хамгаалалтанд орохыг зөвшөөрсөн

Ажил олгогч / /

Жинхэнэ хамгаалалтанд орох 20.....оны.........сарын..........өдөр

Др хэсэг.

Дипломын ажилд өгсөн зөвлөгөө, шүүмжийн талаархи тэмдэглэл

1. 1. Аюулыг мэдээлэх хуудасыг ламп оруулах
2. Санаа нь маш сайхан б/на.
Стандартыг заалтыг тусгаж оксонь маш сайн б/на.

2. 3. Дүрэ ярих. Процессыг сайжруулах
4. Зохион байгуулалт. Самбарыг ашиглах.
5. Ажлын төлөвлөгөөг сайжруулах.
Видео контент дээр суу үг б/хгүй болох (болон?)

3. Тоо баримтуудыг зөв авах.
Заавар чиглэл, (хуучирсан, дахин) ямаг хэлэх.
Мэдлэгээ сайн батлах.
Стандартаа бүрэн гүйцээж бүрт оруулах.

4. Стандартыг нэр бичих.
Тоног ашигт нэр хатаагүй соих
Дүгнэлт дахин боловсруулах (эрнэлтэй видео контент хийх ялсаад

5. тусгайдсан дүгнэл яагаж сайжруулсан талаар бичих).
Зургийг поросу байрлуулж нт интерк дээрх засах
Үг үсгийн алдаанд дээр анхаарах.

Зөвлөгөө шүүмж бичсэн:

Ажил албан тушаал:

Овог нэр.................................................гарын үсэг..... [signature]

УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

2022 оны 06 сарын 20 өдөр

## ДИПЛОМЫН АЖЛЫН ДААЛГАВАР

ХАБ-ын зааварчилгааны видео контент бэлт.

............................................овогтой ................................................нд

Дипломын сэдэв.......................................................................................................

ХАБ-ын зааварчилгааны видео контент

...........................................................................................................................

Судалгааны үндсэн хэсэг............................................................................................

Сургуулийн ХАБЭА журмын дагуу

зааварчилгааны видео контент бэлтгэх

...........................................................................................................................

Судалгааны дүгнэлт, санал.........................................................................................

Төлөвлөсөн ажил бүтээл нь сургуульд

хэрэгцээтэй үр дүнтэй сайн зааварчилгааны

контент болсон байна.

Удирдагч багшийн үнэлгээ.............................................................

Дипломын ажлыг эхэлсэн: 2022 оны 01 сарын..........өдөр

Диплом ажлыг дууссан 2022 оны 05 сарын 10 өдөр

Удирдагч багш / [illegible] /

Урьдчилсан хамгаалалтанд орох: 2022 оны 05 сарын 20 өдөр

Жинхэнэ хамгаалалтанд орохыг зөвшөөрсөн

Ажил олгогч / /

Жинхэнэ хамгаалалтанд орох 2022 оны 05 сарын 23 өдөр

УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

2022 оны 05 сарын 20 өдөр

ДИПЛОМЫН АЖЛЫН ДААЛГАВАР

УУХААТ-3а овогтой ХАБЭА танилцуулга видео контент нд

Дипломын сэдэв MNS 4969:2000 стандартын ХАБЭА зааварчилгаа

Судалгааны үндсэн хэсэг 4969:2000 стандартын үйлчилгээ зөвхөн урьдчилсан зааварчилгааг хэрхэн яаж өгөх талаар судалгаа хийж, шторкондоо оюутнуудаа багаараа оролцож сургуулийн ХАБЭА дүрэм журам, уриаг мэдэх.

Судалгааны дүгнэлт, санал Шторк нь шинэлэг үзэгдэл ашиглаж болох давуу талтай байлаа. Шторкон дээр гарч байгаа бичвэрийн алдааг засах

Удирдагч багшийн үнэлгээ 90 A.

Дипломын ажлыг эхэлсэн: 2022 оны 03 сарын .........өдөр

Диплом ажлыг дууссан 20.....оны.........сарын..........өдөр

Удирдагч багш / /

Урьдчилсан хамгаалалтанд орох: 2022 оны 05 сарын 20 өдөр

Жинхэнэ хамгаалалтанд орохыг зөвшөөрсөн

Ажил олгогч / /

Жинхэнэ хамгаалалтанд орох 20.....оны.........сарын..........өдөр

## ТӨСӨЛТ АЖЛЫН ТОВЪЁОГ

1. Төслийн үндэслэл
2. Зорилго
3. Хүрэх үр дүн
4. Төсөлт ажлын төлөвлөгөө
5. Шаардлагатай тоног төхөөрөмж болон хүмүүс
6. Хяналтын болон ажилласан цагийн хуудас
7. Нэмэлт зургууд
8. Дүгнэлт
9. Сайжруулах зүйлс
10. Сайжруулсан зүйлс

# Төслийн үндэслэл

Бидний хийж буй төсөлт ажил нь Политехник Коллежид дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны зааварчилгааг видео контент хэлбэрээр бэлтгэн,нийт багш ажилчид болон сургуулиар зочилж танилцаж буй зочдод зааварчилгааг өгөхөд ашиглах зорилготой.

Танилцуулга видео контент нь байгуулга, хувь хүний өнгө төрх үйл ажиллагааг илэрхийлэх богино хэмжээний бичлэг юм. Энэ нь танилцуулга, сурталчилгаа, уриа лоозон, зааварчилгааны хэв шинжтэй байна. Сонгуульд нэр дэвшигч өөрийгөө танилцуулж,суртчилсан АТГ, ЦЕГ гэх мэт байгуулагууд авилгал, гэмт хэргийг багасгахыг уриалсан шинжтэй байна. Үйлдвэр уурхайн хувьд дотоод дүрэм журам, үйлдвэрийн нөхцөл байдал дагаж мөрдөх дүрмийг зааварчилсан гэх мэтээр шторк видеог мэргэжлийн хүмүүсээр хийлгэдэг.

Бүтээлийг хийхдээ МАК Евроблок компанийн ХАБЭА-н зааварчилгаа шторкноос ерөнхий санаагаа авсан болно.

Бүтээлийг хийхдээ Монгол улсын MNS 4969:2000 стандартыг гол болгосон.

## Төслийн зорилго

Говьсүмбэр аймгийн Политехник коллежид дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны урьдчилсан зааварчилгааг видео контент хэлбэрээр бэлтгэн Монгол улсын MNS 4969:2000 Стандартын 4.1-4.6 заалтын дагуу урьдчилсан зааварчилгааг багш ажилчид, оюутан суралцагч, сургуультай танилцах гэж буй зочид төлөөлөгч нарт видео хэлбэрээр өгөхөд ашиглах зорилготой.

## Төслийн хүрэх үр дүн

Манай багийн хийж буй төслийн хүрэх үр дүн нь Политехник Коллежийн нийт багш, ажилчид, оюутнууд болон сургуультай танилцаж буй зочид төлөөлөгчид, сурагчид, эцэг эхчүүдэд ХАБЭА-н урьдчилсан зааварчилгааг өгснөөр гэнэтийн аюул ослоос өөрийгөө болон бусдыг хамгаалах, сургуулийн орчинд гэмтэж бэртэхээс сэргийлэх үр дүнд хүрнэ.

## 4 Үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллага дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт

**4.1** Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг зааварчилга өгөх хэлбэрээр зохион байгуулна.
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилга дараах 3 хэлбэртэй байна. Үүнд:

1. Урьдчилсан зааварчилга
2. Ажлын байран дахь анхан шатны зааварчилга
3. Давтан зааварчилга

**4.2** Зааварчилгын хөтөлбөр, хичээлийн сэдвийг хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан боловсруулж, ҮЭ-ийн байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр тухайн байгууллагын ерөнхий менежер (инженер), орлогч дарга батална.

**4.3** Шинээр ажилд орсон ажилтан, үйлдвэрлэлийн сургалт, дадлага хийхээр ирсэн оюутан, суралцагчдад тэдний ажилласан жил боловсролын түвшинг харгалзахгүйгээр урьдчилсан зааварчилга өгнө.

**4.4** Урьдчилсан зааварчилгын агуулга нь хөдөлмөрийн хууль, тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, заавар, улсын стандарт, тухайн байгууллагын өвөрмөц онцлог, дотоод дүрэм, техникийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, ариуйн цэвэр, галын аюулгүй байдал, хувийн хамгаалах хэрэгсэл, үйлдвэрлэлийн осол, МШӨ, хурц хордлого, үүсэх шалтгаан, осолдогчдод үзүүлэх анхны тусламж зэрэг болно.

**4.5** Урьдчилсан зааварчилгыг хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн кабинет, сургалтын техник хэрэгслээр тусгайлан тоноглогдсон анги, танхимд уг асуудлыг хариуцсан удирдах буюу инженер техникийн ажилтан өгнө.

**4.6** Урьдчилсан зааварчилга өгөх хугацаа нь тухайн техник технологийн салбарын аюулгүй ажиллагааны дүрэмд заасан хэмжээгээр тогтоогдох бөгөөд 2 цагаас багагүй байна.

**Говьсүмбэр аймаг дахь Уул уурхайн жишиг сургууль**
**Политехник коллежийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам**

## Нэг: Зорилго.

1.1 Энэхүү журмын гол зорилго нь Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежид ажиллаж буй багш, ажилтан, оюутан, суралцагчид Монгол Улсын ХАБЭА-н хууль, дүрэм, журам, заавар, стандартууд, байгууллагын дотоод дүрэм, журам болон аюулгүй ажиллагааны шаардлага, нормативыг чанд мөрдөн ажиллах, ослоос урьдчилан сэргийлэх, аваарь осолгүй орчин бүрдүүлж, ажиллахад оршино.

## Хоёр: Хамрах хүрээ, хяналт

2.1. Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн багш, ажилтан, оюутан, суралцагчид нийтээр дагаж мөрдөнө.

2.2. Багш, ажилтан, оюутан, суралцагчид ХАБЭА-н журмын дагуу ажил үүргээ гүйцэтгэх бөгөөд журмын дагуу ажиллаж буй эсэхэд харъяалах албадын дарга, салбарын эрхлэгч нар хяналт тавьж ажиллана. Ямар нэгэн аваарь осол гарах магадлал, нөхцөл бий болсон, аюул илэрсэн тохиолдолд ажлыг шууд зогсоож нэн даруй урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, ХАБЭА-ын ажилтан, харъяалах дээд удирдлагад яаралтай мэдэгдэнэ.

2.3. Зөрчлийг нуун дарагдуулсан тохиолдолд хуулийн дагуу хариуцлага тооцно.

## Гурав: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг зарчим

### 3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа

3.1 Лаборатори, мастерын газар, дасгалын талбай, үйлдвэр-сургалтын дадлагын полигон, уурхай, аж ахуйн газарт дадлага удирдаж байгаа багш, ажилтан, дадлага хийж буй оюутан, суралцагчид хөдөлмөрийн аюулгүй байдлын (ХАБ-ын) дүрэмт хувцас, хувийн хамгаалах хэрэгслүүдийг (каск, ажлын хувцас, бээлий, хамгаалах нүдний шил) дүрэм, журмын дагуу бүрэн, зөв өмсөж хэрэглэнэ.

3.2 Багш, ажилтан нар ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн үйл ажиллагаа, хуваарьт ажлын дагуу, оюутан, суралцагчид үйлдвэр сургалтын дадлагын график төлөвлөгөөний хүрээнд үйлдвэр, сургалтын дадлагын удирдамжийн хүрээнд өгөгдсөн ажил, үүргийг гүйцэтгэнэ.

3.3 Ажил, дадлага сургалт эхлэхийн өмнө багш, ажилтан, оюутан, суралцагчид өгөгдсөн ажлын даалгавар, удирдамжийн дагуу дадлага удирдагч багш, ажилтан хөдөлмөрийн хамгаалал аюулгүй

ажиллагааны зааварчилгааг оюутан, суралцагчдад өгч, журнал дээр гарын үсэг зуруулан өгсөн мэдээллийг дахин нягталж ажилд гарна.

3.4 Дадлага, лабораторийн ажил удирдагч багш, ажилтан ажил эхлэхийн өмнө тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг заавал шалгана.

3.5 Машин механизм, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасан хугацаанд тогтмол хийж байна.

3.6 Тос тосолгооны материал нэвчсэн, шатдаг хог хаягдлыг **"ШАТАХ ЗУУХ"** тэмдэг бүх зориулалтын саванд хийнэ.

3.7 Цахилгааны щитийг дур мэдэн (автомат,пускатель) оролдох, тоног төхөөрөмж залгаж холбохыг хориглох ба зөвхөн удирдлагын зөвшөөрлөөр томилогдсон мэргэжлийн ажилтан (цахилгааны инженер, цахилгаанчин) цахилгааны ажлыг гүйцэтгэнэ. Цахилгааны засвар үйлчилгээний ажлыг хийж байгаа үед хүчдэлийг бүрэн салгасны дараа цахилгаан щит болон цахилгаан тоног төхөөрөмжийн гар болон алсын удирдлаган дээр **"Бүү залга, хүн ажиллаж байна"**, **"ЗАЛГАЖ БОЛОХГҮЙ ХҮН АЖИЛЛАЖ БАЙНА"** гэсэн хориглосон плакат, тэмдэглэгээ өлгөнө.

3.8 Цахилгааны щитэнд **"АНХААР ӨНДӨР ХҮЧДЭЛ"** гэсэн анхааруулсан плакат, тэмдэглэгээ байрлуулах ба бүх ажилчид цахилгаан хүчдэлд нэрвэгдэхээс урдчилан сэргийлж, анхааралтай ажиллана.

3.9 Суурь машин дээр ажиллах, гагнуурын ажил хийх үед хамгаалалтын баг болон хамгаалалтын нүдний шилийг заавал хэрэглэнэ.

3.10 Ажил дууссаны дараа тоноглолоо бүрэн зогсоож, хүчдэлээс нь бүрэн чөлөөлсний дараа ажлын байраа цэвэрлэж, хэрэглэсэн ба илүү гарсан материалыг эмх цэгцтэй зориулалтын талбайд хураана.

3.11 Сургуулийн байр, техникийн суурь лаборатори, дадлагын газар, дасгалын талбай, дотуур байрны галын аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагад нийцсэн галын анхан шатны багаж хэрэгсэл (галын хор, элстэй хайрцаг, хувин г.м) эмнэлгийн анхны тусламжийн эмийн сангаар хангагдсан байх бөгөөд эдгээрийг зөвхөн шаардлагатай онцгой тохиолдолд ашиглана. Эмийн сангийн эм, холбогдох материалын ашиглалтын хугацааг сар бүрийн 20-нд шалгаж, шинэчлэнэ.

3.12 Галын аюулаас урьдчилан сэргийлэх, бусдын эрүүл мэндийг хамгаалах үүднээс Сургуулийн байр, техникийн суурь лаборатори, дадлагын газар, дасгалын талбай, оюутны дотуур байр, нийтийн бие засах, үйлчилгээний газарт тамхи татахыг хориглох бөгөөд зөвхөн

тамхийг тухайн объектуудаас 40м хол зайд эсвэл, зөвшөөрөгдсөн цэгт очиж татна.

3.13 Болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх дохио өгсөн, онцгой байдал үүссэн үед **" ЦУГЛАХ ЦЭГ"** гэсэн таних тэмдэг бүхий байрлалд цугларна. **"ЦУГЛАХ ЦЭГ"**-ийг сургуулийн захиргаанаас тогтоож хүн бүхэнд мэдэгдэж мэдээлсэн байна.

3.14 Сургуулийн байр, техникийн суурь лаборатори, дадлагын газар, дасгалын талбай, анги, танхимд хэрэглэгдэж буй тоног төхөөрөмжийн гадаргуу дээр хариуцан ажиллуулж буй тухайн багшийн зурагт танилцуулга, мэдээлэл, бусад этгээдүүд ашиглахгүй байх санамж бүхий мэдэгдэх хуудас байрлуулсан байна.

**4. Цагийн хуваарийг мөрдөх**

4.1. Политехник коллежийн дүрэмд заасны дагуу ажил, амралтын цагийн хуваарийг мөрдлөг болгоно.

**5. Харуул хамгаалалт**

5.1. Политехник коллежийн сахилга бат, аюулгүй байдал, хамгаалалтыг ханган ажиллах харуулийн хуваарь гарган мөрдөж ажиллана.

5.2. Харуул нь ээлжинд гарахаас өмнө ХАБЭА-н зааврын шаардлагад нийцүүлэн хувцаслаж бэлтгэсэн байна. (4-өөс доошгүй цаг унтаж , амрах, сайн хооллох сэтгэл санаа тайван байх) архи, согтууруулах ундаа хэрэглээгүй байна

5.3. Ажил, үүрэг гүйцэтгэсэн хугацаанд гарсан аливаа өөрчлөлт, зөрчлийн талаар ажлын журналд тэмдэглэж дараагийн ээлжийн харуулд танилцуулах, үүрэг гүйцэтгэх хугацаанд эрсдэлтэй бүхий нөхцөл үүссэн тохиолдолд зохих арга хэмжээг авч хариуцсан ажилтан, албаны дарга, сургуулийн удирдлага, холбогдох байгууллагад яаралтай мэдэгдэнэ.

5.4. Анги, лаборатори, өрөө, заал, граж, сургалтын байрны цонх, хаалга, хамгаалах хэрэгслэлийг шалган хариуцсан хүнээс түлхүүрийг авна. Мөн бүрэн бүтэн байдлыг шалгуулан түлхүүрийг хүлээлгэн өгч байна.

5.5. Үйлчилгээний ажилтан нарын ажилд хяналт тавьж, эвдэрч хэмхэрсэн эд зүйл, техник, хэрэгсэл гарвал засуулж янзлах талаар холбогдох хүмүүст мэдэгдэнэ.

**6. Эрүүл ахуй**

6.1. "Хог хогийн саванд" гэсэн зарчмаар ажиллах.

6.2. Тамхи татах цэгт тамхи татах, татсан тамхины иш, хаягдах хайрцгийг зориулалтын тэмдэглэгээ бүхий саванд хийж байх.

6.3. Ил, задгай, гадна талбайд шүлс, цэрээ хаяхгүй байх.
6.4. Эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн хоол хүнсэнд хэрэглэх.

## 7. Хориглох зүйл

7.1. Гагнуур, токарь, механик, хөдөлгүүрийн лаборатори, машин механизм дээр ажиллаж байх үед эмэгтэй багш, оюутан, суралцагчид үсийг задгай тавихгүй, зориулалтын алчуур, боолтоор битүү боож уясан байна. Мөн тухайн багш, оюутан, суралцагчийн үс хэт урт, хүзүү, чихнээс 3 см ил тохиолдолд битүү алчуур, хамгаалалтын боолт хийсэн байна.
7.2. Гагнуурийн ажил хийх үед ил гал гаргахыг хатуу хориглоно.
7.3. Суурь машин ажиллаж байх, тухайн ажилуулж буй хүнээс бусад хүмүүс заагдсан аюулгүйн шар бүсээс дотогш байрлахыг хатуу хориглоно.
7.4. Машин механизм, багаж хэрэгсэл ажиллаж байх үед хөрөө, шүд, эргэх эд ангид ойртох, хориотой хөдөлгөөн, үйлдэл хийхийг хориглоно.
7.5. Суурь машины хутга, хөрөө, эргэлдэх механизмыг төмөр, модоор зогсоохыг хориглоно.
7.6. Бороо, цас орж байгаа үед гадаа цахилгаан тоног төхөөрөмж ажиллуулах ажил үйчилгээ хийхийг хатуу хориглоно.
7.7. Тоосноос хамгаалах хошуувч, маскийг агаар муутай орчинд хэрэглэхийг хориглоно.
7.8. Ил талбай, ажлын байранд машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа материалуудыг зориулалтын бус газар эмх цэгцгүй буулгах, хураах, байрлуулахыг хориглоно.
7.9. Ажлын талбарт байгаа нүх, шуудуунд хамгаалалтын тууз хийж хориглосон болон анхааруулсан плакат, тэмдэглэгээг хүний нүдэнд харагдах газарт байрлуулах ба барилгын талбайн ухсан нүх шуудууны дээгүүр харайж гарахыг хориглоно.
7.10. Ажлын байранд согтуу ирэх ба согтууруулах ундаа мансууруулах зүйл хэрэглэхийг хатуу хориглоно.
7.11. Ажлын цагаар ажлын байран дээр өөр хоорондоо муудалцах, зодолдохыг хатуу хориглоно.
7.12. Лаборатори, мастерын газар, дадлагын газар, дасгалын талбай, уурхай, аж ахуйн газарт ХАБ-н дүрэмт хувцас, хамгаалах хэрэгсэлгүй ажил, сургалтын дадлага явуулахыг хатуу хориглоно.
7.13. Тоног төхөөрөмжийг багшийн зааварчилгаагүй ажиллуулахыг хатуу хориглоно.
7.14. Лаборатори, дадлагын газарт удирдлага, багш, зочид хамгаалах хувцас хэрэгсэлгүй орохыг хатуу хориглоно.

7.15. Байгаль орчин болон бусдын эрүүл ахуйг хангах үүднээс ажлын талбайд ил задгай бие засахыг хориглоно.

7.16. Боловсон 00-д бие засахдаа жорлонгийн тавцан дээр гуталтай гарч, ашиглалтын бус байрлалаар бие засахыг хатуу хориглоно.

**Дөрөв: Журам зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага**

4.1 Багш, ажилтан, оюутан, суралцагчид энэхүү журамын хориглох заалт зааварчилгааг зөрчсөн тохиолдолд хөдөлмөрийн хууль, байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээлгэж, зохих ёсны торгууль ногдуулна.

# ТӨСӨЛТ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хийгдэх ажил | Хугацаа | | | | | | | | | Үйл ажиллагааны дэлгэрнгүй |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2/14-<br>2/18 | 2/21<br>2/25 | 3/1<br>3/11 | 3/14<br>3/19 | 3/21<br>4/1 | 4/4<br>4/29 | 5/2<br>5/19 | 5/20 | 5/25 | |
| 1 | Төсөлт ажлын сэдэв сонгох, баг бүрдүүлэх | Багийн бүх гишүүд | | | | | | | | | Политехник Коллежийн нийт багш, ажилчид, сургуультай танилцаж байгаа зочдод өгөх урьдчилсан зааварчилгааг Видео контент байдлаар хийх.<br>Багийн нийт гишүүдэд<br>С.Маралмаа<br>Ц.Мягмарцогт<br>Г.Энхжин Б.Мөнгөнцэцэг<br>Л.Хүрэлчулуун О. Мөнхтулга<br>Д.Шинэбаяр |
| 2 | Мэдээлэл цуглуулах, судалгаа хийх | Мягмарцогт, Мөнгөнцэцэг | Мөнхтулга, Энхжин | Хүрэлчулуун | | | | | | | Интернетээс болон Албан байгууллага Компаны ХАБЭА-н зааварчилгаа шторк үзэж судлах. |
| 3 | Сэдвийн дагуу хийгдэх төсөлт ажлын ерөнхий санааг ярилцах, төлөвлөгөө боловсруулах | | | Багийн бүх гишүүд | | | | | | | Ямар хэв загвартайгаар видео контентыг хийх талаар зөвлөлдөж ерөнхий санааг гаргах. Төлөвлөгөө боловсруулах |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт гаргах | | | | Энхжин Мөнгөн цэцэг | | | | | | Видео камер<br>Компьютер<br>Мэргэжлийн хүн |
| 5 | Төсөлт бүтээлийн эхлэл үе | | | | | Багийн бүх гишүүд | | | | | Багийн бүх гишүүдийн оролцоотойгоор видео контентын талаар судалгаа болон санаануудаа нэгтгэх |
| 6 | Төсөлт бүтээлийн дунд үе | | | | | | Ангийн бүх хүүхдүүд | | | | Видео контентоо хийлгэх мэргэжлийн хүн олох, шаардлагатай мөнгөн дүнг тохиролцож багийн гишүүд болон ангийн хоёр багийн дипломны төсөлт ажлын нийт зардлын төсөв тооцоог нэгтгэж ангиараа зардлыг босгох. |
| 7 | Төсөлт бүтээлийн төгсгөл үе | | | | | | | Марал маа, Багийн бүх гишүүд | | | Дипломны төсөлт ажлын зураг авалт, дуу оруулалт, засварлах ажил, төслийн бичвэрийг хамгаалахад бэлтгэх, PPT файлаа бэлтгэх, шалгах нягтлах, удирдагч багш нарт шалгуулах |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Хяналтын болон ажилласан цагийн хуудас | | | | | | | Марал маа | | | Төлөвлөгөөний дагуу ажилласан эсэхээ шалгаж, баталгаажуулан гарын үсэг зурах |
| 9 | Диплом, төсөлт ажлаа хамгаалах | | | | | | | | Багийн бүх гишүүд | | Дипломын урьдчилсан хамгаалалтад орох |
| 10 | Бүтээл дээр үнэлэлт дүгнэлт авах | | | | | | | | | Багийн бүх гишүүд | Жинхэнэ хамгаалалтанд орох үнэлгээ авах |

## ХЯНАЛТЫН БОЛОН АЖИЛЛАСАН ЦАГИЙН ХУУДАС

| Ажлын төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлууд | Огноо | Ажилласан цаг | Гарын үсэг |
|---|---|---|---|
| **Төсөлт ажлын сэдэв сонгох, баг бүрдүүлэх** | 2/14-2/18 | 3 цаг | Багийн бүх гишүүд |
| **Мэдээлэл цуглуулах, судалгаа хийх** | 2/17-3/11 | 20 цаг | Энхжин<br>Мөнгөнцэцэг<br>Хүрэлчулуун<br>Мягмарцогт<br>Мөнхтулга |
| **Сэдвийн дагуу хийгдэх төсөлт ажлын ерөнхий санааг ярилцах, төлөвлөгөө боловсруулах** | 3/1-3/11 | 8 цаг | Багийн бүх гишүүд |
| **Шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт гаргах** | 3/14-3/19 | 2 цаг | Энхжин<br>Мөнгөнцэцэг |
| **Төсөлт бүтээлийн эхлэл үе** | 3/21-4/1 | 5 цаг | Багийн бүх гишүүд |
| **Төсөлт бүтээлийн дунд үе** | 4/4-4/29 | 20 цаг | Багийн бүх гишүүд |
| **Төсөлт бүтээлийн төгсгөл үе** | 5/2-5/19 | 20 цаг | Багийн бүх гишүүд |
| **Төсөлт ажлын судалгаа болон бичвэр, PPT файл бэлтгэх** | 5/9-5/19 | 10 цаг | Маралмаа |
| **Диплом, төсөлт ажлаа хамгаалах** | 5/20-5/27 | 4 цаг | Багийн бүх гишүүд |
| **Бүтээл дээр үнэлэлт дүгнэлт авах** | 5/27 | 1 цаг | Багийн бүх гишүүд |

Ажилласан цагийг баталгаажуулсан: /........................../

/......................../

## ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ХҮМҮҮСИЙН ЖАГСААЛТ

| № | Тоног төхөөрөмжийн нэр | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зураг авалтын талбай | ширхэг | 1 | Сургуулиас |
| 2 | Камер | ширхэг | 1 | Сургуулиас |
| 3 | Комьпютер | ширхэг | 1 | Сургуулиас |
| 4 | Зураг авалт болон Монтаж засвар хийхэд тусласан багш | ширхэг | 1 | Политехник коллежын Мультимедиагын багш М.Сандагсүрэн |
| 5 | Зураг авалтанд орох хүн | ширхэг | 1 | ХАБЭА-н 3а ангийн оюутан М.Ванчиндорж |
| 6 | Видеоны дуу оруулгад орох хүн | ширхэг | 1 | ХАБЭА-н 3а ангийн оюутан С.Маралмаа |

**Багийн гишүүд төсөлт ажлын төлөвлөгөө болон санаагаа ярилцаж байна.**



**Сандагсүрэн багш төсөлт ажлын видео засварын ажил хийж байна.**



# Төсөлт ажилд ашиглагдсан тоног төхөөрөмж





## Дүгнэлт

- Бүтээлийг хийх үеийн үйл явц болон хөрөнгө санхүү, цаг хугацааны хувьд хангалттай гэж үзэж байгаа бөгөөд цаашид Говьсүмбэр аймгийн Политехник коллежийн ХАБЭА-н урьдчилсан зааварчилгааны видео болгон ашиглахад боломжтой гэж үзэж байна.
- Энэхүү бүтээлтэй төстэй болон ижил видео зааварчилгааг бусад сургалтын байгууллагуудад ашиглагддаг эсэх нь тодорхой бус байгаа ч манай сургуулийн хувьд анхны ХАБЭА-н зааварчилгаа видео хийгдсэн болно.
- Бүтээлч ажлыг хийх явцдаа оюутнууд зөвхөн судалгаа шинжилгээний ажил хийгээд зогсохгүй тухайн бүтээлийг хийх ур чадвар, мэдлэг туршлага нэмэгдэж байгаа юм.
- Бүтээлийг хийхэд багийн 7 гишүүдийн санаа болон цаг, хөрөнгө санхүү орсон болно.

Задаргаа:

- Видео бичлэгний дүрс болон засварын ажилд /100,000 төгрөг/
- Сургуулиас ашигласан тогны зардал /50,000 төгрөг/

**Сайжруулах зүйлс:**

Видео контентны дүрс авах ажил болон дуу оруулах ажлыг засварлах мөн нэмэлт зүйлүүд оруулж болно.

**Сайжруулсан зүйлс:**

- ✓ Төслийн сэдвийн нэр зөв болгосон
- ✓ Багийн гишүүдийн оролцоо нэмэгдсэн
- ✓ Видеоны  тайлбар хэсгийн үгийн алдаа зассан
- ✓ Тоон мэдээллийг зөв болгосон
- ✓ Санхүүгийн тооцоолол нэмсэн
- ✓ Дотуур байрны мэдээлэл нэмсэн
- ✓ Видеоны эхлэл болон төгсгөл хэсгийн хоолойг дахин бичүүлсэн
- ✓ Видеоны төгсгөл хэсэгт сургуулийн уриаг нэмж оруулсан